



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 196 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Тээврийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нийслэлийн Тээврийн газрын дотоод журмыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллахыг Тээврийн газар /Ч.Сайханбаяр/-т даалгасугай.

Гурав. Нийслэлийн Тээврийн газрын шинэчилсэн дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлтийг хангаж ажиллахыг Тээврийн газар /Ч.Сайханбаяр/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2004 оны 387 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2007 ОНЫ
3 САРЫН 19-НЫ ӨДРИЙН 96 ДУГААР
ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Тээврийн газар нь /цаашид газар гэх/ Улаанбаатар хотын тээврийн салбарыг хөгжүүлэх, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, автотээврийн хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, норм, стандарт, дүрэм, журмыг хангуулах, нийтийн тээвэр, ахуйн тээвэр, ачаа тээврийн зэрэг зорчигч тээврийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангуулахаар нийтийн тээврийн үйлчилгээг зохицуулан зохион байгуулж хянаж шалгах үүрэг бүхий Нийслэлийн өмчит статустай мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Газар нь Монгол Улсын "Үндсэн хууль", "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Авто тээврийн тухай" хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

1.4. Тус газар нь Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15-д оршино.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт.

2.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Тээврийн газрын бүтэц, орон тоог тогтоож үйл ажиллагааны дүрмийг баталж, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө Тээврийн газрын дарга ажлаа тайлагнана.

2.3. Газрын дарга нь төсвийн Ерөнхийлөн захирагчтай "Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ"-г Нийслэлийн өмчийн харилцааны газартай хөрөнгийн ашиглалт зарцуулалтын асуудлаар тус тус гэрээ байгуулж ажиллана.

2.4. Газрын даргыг ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, удаан хугацааны сургалт, томилолтын хугацаанд Ерөнхий инженер орлоно.

2.5. Газрын даргын бүрэн эрх:

2.5.1. Эрхлэх асуудлын хүрээнд тушаал шийдвэр гаргана.

2.5.2. Ерөнхий инженерийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр томилж чөлөөлнө.

2.5.3. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулна.

2.5.4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг баталж цалингийн хэмжээг тогтоож мөрдүүлэх бөгөөд байгууллагын ажлыг удирдан цаг үеийн ажлын зохион байгуулна.

2.5.5. Батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсдыг томилох чөлөөлөх хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагад зохицуулан тодорхой хугацаагаар гэрээгээр мэргэжлийн хүн ажиллуулна.

2.5.6. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд бүртгэл зохицуулалт, хяналт тогтоох үүрэг бүхий диспетчер ажиллуулна.

2.5.7. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн тайланг авч үнэлэлт дүгнэлт өгч, зохих журмын дагуу шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, нийгмийн асуудлыг шийдэх, гадаад дотоодын сургалтанд хамруулж ажиллана.

2.5.8. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, ажлын байрны тав тух, соёлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5.9. Хууль, удирдах дээд байгууллага болон энэ дүрмээр олгогдсон бусад эрхийг эдэлнэ.

2.6. Газрын даргын дэргэд зөвлөх үүрэг бүхий зөвлөл ажиллана. Газрын дарга зөвлөлийн гишүүдийг томилж, зөвлөлийн ажиллах журмыг батална.

Гурав. Санхүүжилт

3.1. Газар нь төрийн ажил үйлчилгээ үзүүлсний үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

3.2. Тус газрын орлого нь нийтийн зорчигч тээврийн ажил үйлчилгээ эрхлэж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад бүртгэл, зохицуулалт, мэдээлэл, хяналтын ажил үйлчилгээ үзүүлсний болон бусад орлогоос бүрдэнэ.

Дөрөв. Газрын үүрэг

4.1. Газар нь дараах үүрийг хүлээнэ Үүнд:

4.1.1. Улаанбаатар хотын тээврийн салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогыг төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх хууль, эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлж ажиллах

4.1.2. Нийслэл хотын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх, түүнтэй холбогдсон эрх зүйн баримтуудыг боловсронгуй болгох талаар санал, төсөл боловсруулж, холбогдох дээд газруудад тавьж шийдвэрлүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх

4.1.3. Хотын нийтийн тээврийг хөгжүүлэх, түүний материаллаг баазыг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгө оруулалт хийх болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээд тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үндэслэл, судалгааг гаргах, төсөл хэрэгжүүлэхэд оролцох

4.1.4. Нийслэлийн нийтийн тээврийн автобус троллейбус, таксийн тээврийн үйлчилгээний хүрээг нэмэгдүүлж чиглэл, маршрут, буудал, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, баталгаажуулах, тохижуулж тэмдэгжүүлэх талаар судалгаа тооцоо хийж санал боловсруулж шийдвэрлүүлэх

4.1.5. Нийслэлийн нийтийн тээврийн эрэлт хэрэгцээг хангуулах зорилгоор үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, хөдлөх бүрэлдэхүүн, паркийг оновчтой болгох, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, техник ашиглалтын шаардлагад илүү нийцтэй, эдийн засгийн хэмнэлттэй тээврийн хэрэгслийг сонгож ажиллах талаар санал, төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх

4.1.6. Нийтийн зорчигч тээвэр, ачаа болон ахуйн тээврийн, үйлчилгээний, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үздэг оношлогооны үйл ажиллагаатай

холбогдсон стандарт, норм, норматив, жишиг үнийн тарифын үндэслэл боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах

4.1.7. Хотын нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн харилцаа, төрийн бодлоготой уялдуулан, тогтвортой уян хатан байлгах бодлогыг хэрэгжүүлэх

4.1.8. Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээний шугам чиглэл бүрээр орлого зардлын тооцоог хийж, нийгмийн шаардлагаар зайлшгүй алдагдалтай ажиллах чиглэлийн алдагдлыг нөхөх асуудлыг боловсруулж Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх

4.1.9. Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулах, аттестатчилал явуулж түвшин тогтоох ба үйлчилгээний чанар соёлч байдлыг дээшлүүлэх, иргэдийн ахуйн болон ачаа тээврийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх

4.1.10. Нийслэлийн хэмжээнд авто тээврийн оношлогоо, техникийн хяналтын үзлэг зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох

4.1.11. Иргэдийн ачаа ахуйн тээврийн болон захиалгат үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтанд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх

4.1.12. Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бүртгэл мэдээлэл, хяналтын автомат системийн хэвийн үйл ажиллагааг хангах, өргөтгөх, мэдээллийн программ хангамжийг нэмэгдүүлэх сайжруулах, орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх

4.1.13. Авто тээвэрлэлтийн үйл ажиллагаанд төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслэл болон үйлчилгээнд тавигдах шаардлагыг стандартын дагуу хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд мэргэжлийн хяналтын төв байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах

4.1.14. Нийслэлийн хэмжээнд тээврийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ тээврийн хэрэгслийн үйлчилгээний замын хуудас болон нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхийн үнэмлэх зэрэг бичиг баримт, зорчигчийн тасалбар, оюутны хөнгөлөлтийн марк зэрэг үнэт цаасыг батлагдсан загварын дагуу нэгдсэн журмаар хэвлүүлж хангах

4.1.15. Нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлөлтэй болон үнэ төлбөргүй зорчих эрх иргэдийн унааны зардлын нөхөн олговорт шаардагдах хөрөнгийг улс нийслэлийн төсөвт тусгуулах, санхүүжилтийг авч нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын гүйцэтгэлийг үндэслэн хуваарилан олгоно.

4.1.16. Нийслэлийн тээврийн салбарын хүний нөөцийн бодлогын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

Тав. Газрын эрх

5.1. Газар нь дараах эрхийг эдэлнэ.Үүнд:

5.1.1. Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын өмч хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, захиран зарцуулах

5.1.2. Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэнд тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага ажил үйлчилгээний гэрээний үүргийг ханган биелүүлээгүй тохиолдолд түүнийг хүчингүй болгох

5.1.3. Газрын хариуцах асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагатай бие даан харилцах, гэрээ байгуулах, хэлцэл хийх

5.1.4. Нийслэлийн Засаг дарга холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гадаад орны болон өөрийн улсын байгууллагатай хэлцэл хийх гэрээ байгуулах, бусад асуудлаар хамтран ажиллах

5.1.5. Улаанбаатар хотын тээврийн салбарыг хөгжүүлэх, үйлчилгээний бүртгэл хяналт, зохицуулалтад шинэ техник технологи нэвтрүүлэх төсөлд техник эдийн засгийн үндэслэл дүгнэлт хийж санал боловсруулах

5.1.6. Улаанбаатар хотын зорчигч тээврийн сүлжээг шинэчлэн өөрчлөх, хотын үйлчилгээний маршрут чиглэл, буудал зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх

5.1.7. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр өөрийн салбар нэгжийг байгуулан ажиллуулах

5.1.8. Авто тээврийн салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмын биелэлтэнд хяналт тавьж, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил дутагдалд хуулийн дагуу хариуцлага тооцох, зөрчлийг арилгуулах албан шаардлага мэдэгдэл өгөх, гэрээг цуцлах

5.1.9. Хууль болон Нийслэлийн Засаг даргаас олгосон бусад эрхийг эдлэх

Зургаа.Эд хөрөнгө санхүүгийн бүртгэл хяналт

6.1. Газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлнө.

6.2. Тээврийн газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн тайлан тэнцлийг улирлаар гаргаж татварын алба санхүүгийн байгууллагад тушаана.

6.3. Санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байна.

6.4. Газар нь үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн дотоодын болон улсын тооллогыг хуулинд заасан хугацаа журмыг үндэслэн явуулна.

6.5. Тус газар нь өмч хөрөнгөө эзэмших, ашиглах түрээслүүлэх, шилжүүлэх, худалдах, устгах, хувьчлах, үнэлэх асуудлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуульд заасан журам, эрх хэмжээнд хэрэгжүүлнэ.

6.6. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд өдөр тутамд тавих дотоодын хяналтыг зохион байгуулж үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө газрын дарга, бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

6.7. Эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, эд хариуцагчийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу сонгон авч "Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ"-г байгуулан ажиллана.

Долоо. Хариуцлага

7.1. Тус газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг мөрдөнө.

7.2. Ажил үүргээ биелүүлэх явцдаа санаатайгаар байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтан сахилгын захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг үл харгалзан эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.

Найм. Бусад

8.1. Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь энэ дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг зохих байгууллагад бүртгүүлнэ.